

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

Шударга, ил тод сонгуулийн үйл ажиллагааг автоматжуулахтай холбогдсон харилцааг Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиар зохицуулна. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд зааснаар сонгуульд ашиглах автоматжуулсан техник хэрэгслийн иж бүрдэл, программ хангамжийг урьдчилан туршихгүйгээр сонгуулийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглодог. Хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд олон талт төлөөллөөс бүрдсэн хараат бус Ажлын хэсэг байгуулсан байдаг.




СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ИЖ БҮРДЭЛ

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд тодорхойлсноор “автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл” гэж сонгогчийн болон санал хураалтын мэдээллийг оруулах, түүнийг боловсруулах, нэгтгэх, хадгалах, хайх болон үр дүнг дамжуулах зориулалттай, харилцан уялдаатай техник хэрэгсэл, программ хангамжийн нэгдлийг хэлдэг.

Сонгуулийн автоматжуулсан систем нь санал тоолох төхөөрөмж /New Image Cast/-ийн иж бүрдэл болон бүртгэлийн техник хэрэгслээс бүрдэнэ.

Одоогийн бидний ашиглаж буй **“Dominion Voting Systems”** компаний бүтээгдэхүүн **“Image Cast Precinct”** гэдэг төхөөрөмж бол сонгуулийн хэсгийн санал авах байранд суурин саналын хайрцагтай лацдан байрлуулж, сонгогчийн саналаа тэмдэглэсэн саналын хуудсыг унших, саналын хуудсан дээрх сонгогчийн



тэмдэглэсэн санал тэмдэглэгээг тоолж, дүнг нэгтгэх болон нэгтгэсэн дүнг Сонгуулийн Ерөнхий Хорооны төв серверт өндөр хамгаалалт бүхий тусгай сувгаар дамжуулах үүрэгтэй, сканнер хэлбэрийн хагас автоматжуулсан төхөөрөмж.

Уг систем нь Монгол Улсын “Сонгуулийн автоматжуулсан систем”-ийн тухай хуульд заасан шаардлагуудыг бүрэн хангасан бөгөөд сонгуульд ашиглахын өмнө төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагууд, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн төлөөллийг байлцуулан шалган туршиж, мэдээллийн технологийн мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн Ажлын хэсэг баталгаажуулж, санал тоолох төхөөрөмж тус бүрд гэрчилгээ олгодог.

Манай улсын сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй сонгуулийн автоматжуулсан систем нь санал авах өдөр ажиллаж байх үедээ ямар нэгэн сүлжээнд холбогдолгүй ажилладаг бөгөөд олон баримт үлдээдэг гэдгээрээ давуу талтай.

Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа төхөөрөмжид аль ч талаар нь харуулан уншуулахад саналын хуудсыг сканердан зургийг нь авч төхөөрөмжийн санах ойд хадгалдаг. Мөн тэмдэглэсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг сонгуулийн санал авах өдөр 22 цаг болмогц хэсгийн хэмжээнд нэгтгэн ямар нэгэн сүлжээнд холбохоос өмнө дүнгийн тайланг хэвлэн ажиглагчдад газар дээр нь хангалттай хэмжээгээр хэвлэж өгдөг. Ийнхүү дүнгийн хуудсыг хэвлэж өгсний дараа тусгай модемын тусламжтай сүлжээнд холбогдож дүнгээ дамжуулна. Мөн хэсгийн хороонд ажиллаж байгаа ажиглагчдад тухайн хэсгийн санал авах байрны санал тоолох төхөөрөмжид уншигдсан бүх саналын хуудасны зурган файлыг CD дээр буулгаж өгдөг. Эдгээр бүх мэдээлэл нэгтгэгдэж байж сонгуулийн албан ёсны дүн гардаг.

Сонгуулийн бүхий л үйл явцыг нээлттэй, ил тод, шударга зарчмаар явуулахын тулд Сонгуулийн ерөнхий хороо санал авах байруудыг камержуулж, бүхий л үйл явцыг дүрс бичлэгээр давхар баримтжуулж, төв серверээс үндэсний болон олон улсын хэвлэл мэдээлэл, ажиглагч, олон нийтийн төлөөлөлд нээлттэй хянах боломжийг бүрдүүлээд байна. Тухайлбал, 2021 оны 06 дугаар сард зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн

2020 оны ээлжит сонгуулийн санал авах ажиллагааг амжилттай хэрэгжүүлээд байна.